МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 27 өдөр Дугаар 450 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн статистик мэдээллийн
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.8 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистикийн мэдээ тайлан гаргах, мэдээлэх журмыг нэгдүгээрт халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журмыг хоёрдугаарт бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журмыг гуравдугаарт сүрьеэ өвчнийг бүртгэх, мэдээлэх журмыг дөрөвдүгээрт хорт хавдрыг бүртгэх, мэдээлэх журмыг тавдугаарт эрүүл мэндийн бүртгэлийн болон тайлангийн маягтын жагсаалт хадгалах хугацааг зургаадугаарт шинэчлэн боловсруулсан анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтын загварыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өвчний түүх бичих стандартыг 2014 оны эхний улиралд багтаан шинэчлэн боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулан, мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/ Я.Буянжаргал/-т даалгасугай.

3. 2014 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад Өвчний олон улсын 10 дугаар ангиллын 4 тэмдэглээт код, Үйлдлийн олон улсын 9 дүгээр ангиллыг нэвтрүүлэхийг зөвшөөрсүгэй.

4. Эрүүл мэндийн хөгжлийн төв/ Ч.Бат-Эрдэнэ/-д даалгах нь:

4.1. Бүртгэл, тайлангийн шинэчлэгдсэн маягтын загвар хөтлөх зааврыг шинэчлэн боловсруулж, хэвлүүлэх;

4.2. Бүртгэлийн болон тайлангийн маягтанд өөрчлөлт орсонтой холбогдуулан эрүүл мэндийн статистикийн програм хангамжийг шинэчлэх ажлыг тус тус 2014 оны 02 дугаар сарын 01-ний дотор багтаан зохион байгуулах.

002933

5. Бүртгэл, тайлангийн маягтуудыг хэвлүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгах, өвчний түүхийг архивлах, хадгалах өрөөг орчин үеийн шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр тоноглохыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын болон бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

6. Тушаалыг 2014 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

7. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 34 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

САЙД Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11
дугаар сарын 27-ны өдрийн 450 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭ, ТАЙЛАН ГАРГАХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Сарын мэдээ, тайлан

1.1 Бүх шатны улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүд нь хүн амын төрөлт, нас баралт, эх, хүүхдийн эндэгдэл, амбулаторын болон стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлтүүд, амбулатори, стационарын өвчлөл, нас баралтыг өдөр бүр бүртгэн, мэдээлнэ.

1.2 Эрүүл мэндийн байгууллагууд бүртгэгдсэн хүн амын төрөлт, нас баралт, эх, хүүхдийн эндэгдэл, амбулаторын болон стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлтүүдийг батлагдсан маягтын дагуу сар бүр цаасан болон цахим хэлбэрээр мэдээлнэ.

1.3 Сарын мэдээг бүх шатны улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүд тухайн сарын сүүлчийн өдрөөр тасалбар болгоно.

1.4 Сарын мэдээний нэгтгэлийг хувийн эмнэлэг, өрх/сумын эрүүл мэндийн төв, аймаг/дүүргийн нэгдсэн эмнэлэг, төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвүүд нь дараа сарын 2-ны дотор, аймаг, нийслэлийн түвшинд дараа сарын 4-ний дотор багтаан дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ.

1.6 Үндэсний түвшинд сарын мэдээний нэгтгэлийг Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-нд дараа сарын 6-ны дотор, Улсын их хурал, Засгийн газар, Эрүүл мэндийн яам (ЭМЯ) болон бусад холбогдох байгууллагуудад дараа сарын 7-ны дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

1.7 Сэжигтэй болон онош нь батлагдаагүй өвчлөлийг тухайн сарын мэдээнд оруулалгүй, онош баталгаажсны дараа мэдээлнэ.

1.8 Явуулын хүн амын өвчлөл, төрөлт, нас баралтыг тухайн тохиолдлыг бүртгэсэн эмнэлгийн байгууллага мэдээлж, харин тогтмол хаяг гэсэн асуултанд тухайн хүний байнга оршин суугаа газрыг бичнэ. Явуулын хүн ам гэдэг ойлголтонд 6 сараас бага хугацаагаар оршин суугаа болон албан буюу хувийн хэргээр зорчигсод орно.

Хоер. Улирлын мэдээ, тайлан

2.1 Бүх шатны улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүд нь ЭМЯ-наас хүлээн зөвшөөрсөн программ хангамжийг ашиглан амбулатори, стационарын өвчлөл, нас баралтын тохиолдол бүрийг компьютерт шивж, цахим мэдээний санг үүсгэнэ.

2.2 Бүх шатны улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүд нь Хүн амын амбулатори, стационарын өвчлөл, нас баралтын цахим мэдээний санг өдөр, сар, улирлаар нэгтгэж, тайлан гаргана.

2.3 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА нь хүн амын амбулатори, стационарын өвчлөл, нас баралтын цахим мэдээний санг улирлаар нэгтгэн, дараа улирлын эхний сарын 15 гэхэд үндэсний түвшинд цахим хэлбэрээр мэдээлнэ.

2.5 Үндэсний түвшинд хүн амын амбулатори, стационарын өвчлөл, нас баралтын цахим мэдээний санг улирлаар нэгтгэн, дараа улирлын эхний сарын 30 гэхэд аймаг, нийслэлийн ЭМГ-т эргэн мэдээлнэ.

2.6 Өрх болон хувийн хэвшлийн эмнэлгүүд нь Үндэсний статистикийн газрын даргын 2010 оны 01 сарын 11-ний өдрийн 01/04 тоот тушаалаар батлагдсан Улсын тайлан маягт ЭМТ-6-аар "Эрүүл мэндийн байгууллагуудын орлого, зарлагын тайлан"-г улирал болон жилээр гаргана.

2.7 "Эрүүл мэндийн байгууллагуудын орлого, зарлагын тайлан"-г бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд нь аймаг, нийслэлийн ЭМГ-т улирал бүрийн дараа сарын 15-ны дотор, жилийн эцсийн мэдээг дараа оны 2 дугаар сарын 25-ны дотор тус тус цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

Гурав. Жилийн тайлан

3.1 Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд жилийн үйл ажиллагааны тайлан мэдээг тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, батлагдсан маягтын дагуу нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-д цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.2 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-ны мэдээллийн мэргэжилтэн-статистикч их эмч нь аймаг, нийслэлийн түвшинд эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авч, нэгтгэх, дүгнэх, эргэн мэдээлэх ажлыг удирдан зохион байгуулна.

3.3 Сар, улирлын мэдээнүүд нь өссөн дүнгээр жилийн тайланд тусгагдана.

3.4 Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авч, нэгтгэхдээ үндсэн материалтай нь тулган шалгаж, дүгнэлт хийнэ.

3.5 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА нь эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны жилийн тайланг батлагдсан маягт, зааврын дагуу нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 20-ны дотор үндэсний түвшинд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.6 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-ны мэдээллийн мэргэжилтэн-статистикч их эмч нар нь тухайн тайлангийн жилд статистик мэдээ, мэдээлэлд хайхрамжгүй хандсан, үндсэн баримтгүй худал, дутуу, буруу ташаа мэдээлэл өгсөн эмч, эмнэлгийн ажилтан, статистикч эмч нарт хариуцлага тооцох, идэвх санаачлага, үр бүтээлтэй ажилласан ажилтныг урамшуулах, цаашид зохион байгуулах ажлын талаар санал боловсруулж аймаг, нийслэлийн ЭМГ-ын удирдлагын зөвлөлийн түвшинд хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

3.6 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн кабинетийн эмч нар нь төрөлжсөн мэргэжлийн кабинетийн жилийн тайланг батлагдсан маягтын дагуу нэгтгэн, аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-ны мэдээллийн мэргэжилтэн-статистикч их эмчид хүлээлгэн өгнө.

3.7 Төрөлжсөн мэргэжлийн төвүүдийн СМА нь дүүргийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөлжсан мэргэжлийн кабинетаас ирсэн жилийн тайланг нэгтгэж, үндэсний түвшинд дараа жилийн 2 дугаар сарын 1-ний дотор хүргүүлнэ.

3.8 Үндэсний түвшинд эрүүл мэндийн байгууллагуудын жилийн тайлангийн нэгтгэл, статистик боловсруулалт хийж, эрүүл мэндийн салбарын үндэсний хэмжээнд гаргах үзүүлэлтүүдийг тооцно.

Дөрөв. Эргэн мэдээлэл

4.1 Аймаг нийслэлийн ЭМГ-ын СМА нь өрх, сумын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн сар, улирал, жилийн тайлан, мэдээнд нэгтгэл, дүгнэлт хийж, сум, дүүрэг, өрхийн эмнэлгийн түвшинд эргэн мэдээлнэ.

4.2 Үндэсний түвшинд сар бүрийн "Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл" эмхэтгэлийг аймаг нийслэлийн ЭМГ-т дараа сарын 10- ны дотор цахим шуудангаар (вэб хуудас) эргэн мэдээлнэ.

4.3 Үндэсний түвшинд хүн амын амбулатори, стационарын өвчлөл, нас баралтын цахим мэдээний баазад улирал тутам нэгтгэл, дүгнэлт хийж аймаг нийслэлийн ЭМГ, ЭМЯ-ны харьяа эмнэлгүүдэд дараа улирлын эхний сарын 15-ны дотор цахим шуудангаар (вэб хуудас) эргэн мэдээлнэ.

4.4 Үндэсний түвшинд эрүүл мэндийн байгууллагуудын жилийн тайлангийн нэгтгэлд статистик боловсруулалт хийж, эрүүл мэндийн салбарын үндэсний хэмжээнд гаргах үзүүлэлтүүдийг тооцож, дүгнэлт хийн, эмхэтгэл болгон хэвлүүлж ДЭМБ, ҮСГ, ЭМЯ болон холбогдох бусад байгууллага, аймаг, нийслэлийн ЭМГ-т дараа жилийн 4 дүгээр сарын 1 гэхэд хүргүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
11 дугаар сарын 27-ны өдрийн 450 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ХАЛДВАРТ ӨВЧИН, ХАМШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Долоо хоногийн мэдээ

1.1 Өрх, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгүүд бүртгэгдсэн халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдлын мэдээг долоо хоног бүр даваа гаригт харьяа аймаг, нийслэлийн ЭМГ, дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд мэдээлэх хуудасны I хэсгээр мэдээлнэ.

1.2 Аймаг, нийслэлийн ЭМГ нь өрх, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгүүдээс ирүүлсэн халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдлын мэдээг долоо хоног бүр нэгтгэж мягмар гаригт электрон хэлбэрээр ХӨСҮТ-ийн Тандалтын Үндэсний нэгжийн **www.nccd.gov.mn/ewar/** вэб хаяг руу илгээнэ.

1.3 Халдварт өвчний онош батлагдсан тохиолдолд "Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас"-ны I, II хэсгийг хамт бөглөж мэдээлнэ.

1.4 ХӨСҮТ-ийн Тандалтын үндэсний нэгж нь аймаг, нийслэлийн ЭМГ-аас ирүүлсэн бүх мэдээг үндсэн баазад нэгтгэж долоо хоногийн пүрэв гариг бүр эргэн мэдээлнэ.

1.5 "Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас" бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хөтлөгдөнө.

1.6 Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлын мэдээлэх хуудсыг бүх шатны дүн бүртгэл, статистикийн албанд нэгтгэнэ.

1.7 Долоо хоногийн мэдээнд эпидемиологийн хуанлигаар өмнөх долоо хоногийн ням гаригаас дараа долоо хоногийн ням гариг хүртэлх мэдээг хамруулна.

1.8 Босго үзүүлэлтэд хүрсэн тохиолдолд долоо хоногийн мэдээг хүлээхгүйгээр 24 цагийн дотор дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ.

1.9 Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлын долоо хоногийн нэгдсэн мэдээг захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-301.1 тайлангийн маягтаар гарган ХӨСҮТ-ийн Тандалтын үндэсний нэгжид мэдээлнэ.

Хоёр. Сарын мэдээ

2.1 Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд халдварт өвчний онош батлагдсан тохиолдлуудын мэдээг нэгтгэнэ.

2.2 Өрх, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгүүд онош батлагдсан халдварт өвчний мэдээг сар бүр аймаг,

нийслэлийн ЭМГ, дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд дүн бүртгэл, статистикийн албанд мэдээлнэ.

2.3 Онош батлагдсан халдварт өвчний тохиолдлуудыг "Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас" –аар мэдээлнэ.

2.4 Оношийг лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн баталгаажуулахаас гадна зарим шинэ ба ховор халдварын үед үүсгэгчийн хэв шинжээс шалтгаалан өвөрмөц оношлууруудтохирохгүй нөхцөлд ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмчийн үзлэгээр эмнэлзүйн шинж тэмдэг, тархвар судлалын судалгааны дүгнэлтийг үндэслэн эцсийн онош тавьж болно.

2.5 Сарын мэдээнд тухайн сарын 1-ний өдрөөс эхлэн дараагийн сарын 1-ний өдөр хүртэлх мэдээг хамруулна.

Гурав. Жилийн тайлан

3.1 Долоо хоног, сарын мэдээг өссөн дүнгээр гаргаж жилийн тайланд тусгана.

3.2 Аймаг, дүүргийн халдвар судлаач, тархвар зүйч эмч нь үйл ажиллаагааны жилийн тайланг "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-301 тайлан" маягтын дагуу гарган дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-д цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.3 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-ны мэдээллийн мэргэжилтэн-статистикч их эмч үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авч шалган дараа оны 1 дүгээр сарын 20-ны дотор ХӨСҮТ-ийн СМА-нд цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.4 ХӨСҮТ-ийн СМА-ны статистикч эмч нь аймаг, нийслэлийн ЭМГ-аас ирүүлсэн "Халдварт өвчин судлалын кабинетийн үйл ажиллаагааны жилийн тайлан"-г хүлээн авч нэгтгэн үндэсний түвшинд цахим болон цаасан хэлбэрээр дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээлэх урсгал

Халдварт өвчний хамшинж, сэжигтэй, өвөрмөц тохиолдлыг мэдээлэх мэдээллийн урсгал

Гуравдахь шат

ЭМЯ

Үндэсний түвшин (Эрүүл мэндийн статистикийн нэгж)

Онош батлагдсан тохиолдлыг сар бүр

ХӨСҮТ

Пүрэв гаригт эргэн мэдээлнэ

Хоёрдахь шат

Нийслэлийн ЭМГ

Аймгийн ЭМГ

Долоо хоног бүр Мягмар гаригт

Дүүргүүдийн ЭМН

Анхан шат

Долоо хоног бүр Даваа гаригт

Өрхийн ЭМТ

Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлэг

Өрхийн ЭМТ

Сумын ЭМТ, сум дундын эмнэлгүүд

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
11 дугаар сарын 27 өдрийн 450 тоот
тушаалын гуравдугаар хавсралт

БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРЫН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Бэлгийн замаар дамжих халдварыг бүртгэх

1.1 Сумын эрүүл мэндийн төв (лаборатори бүхий), сум дундын эмнэлэг, аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, хувийн хэвшлийн эмнэлгүүд нь онош батлагдсан бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг "Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас" АМ-3 маягтаар бүртгэн аймаг, нийслэлийн ЭМГ-т мэдээлнэ.

1.2 Өрх, сумын эрүүл мэндийн төв нь БЗДХ-ыг хам шинжээр оношлон "Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас" АМ-3 маягтаар мөн бүртгэн аймаг, нийслэлийн ЭМГ-т мэдээлнэ.

1.3 Төрөлхийн тэмбүүгийн сэжигтэй тохиолдлыг тухайн харьяаллын БЗДХ-ын эмч оношийг баталгаажуулан тухайн ЭМБ-ын төрөхийн болон нярайн халдвар судлаач эмч мэдээлнэ.

1.4 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн нэгдлүүдийн нь БЗДХ-ын кабинетийн эмч нь "Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас"-аар (АМ-3 маягт) бүртгэгдсэн тохиолдлыг ЭМЯ-наас хүлээн зөвшөөрсөн программ хангамжийг ашиглан цахим мэдээний санг үүсгэнэ.

Хоёр. Сарын мэдээ

2.1 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА нь онош батлагдсан БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг нэгтгэн дараа сарын 4-ний дотор цахим хэлбэрээр үндэсний түвшинд сар бүр мэдээлнэ.

2.2 "Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас" АМ-3 маягтаар үүссэн цахим мэдээний санг бүртгэлийн маягтын хамт дараа сарын 10-ны дотор ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА- нд сар бүр ирүүлж байна.

2.3 БЗДХ-ын шинжилгээний тайланг эрүүл мэндийн байгууллагын лабораторийн эмч, лаборант нар сар, улирлаар гарган дараа сарын 10-ны дотор цахим болон цаасан хэлбэрээр ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА- нд ирүүлнэ.

2.4 Хам шинжийн оношлогооны сарын тайланг өрх, сумын эмнэлгийн эмч нар гарган аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн БЗДХ-ын кабинетийн эмчид цаасан хэлбэрээр дараа сарын 5-ны дотор хүргүүлнэ.

2.5 БЗДХ-ын кабинетийн эмч нь хам шинжийн оношлогооны сарын тайлангийн нэгтгэлийг дараа сарын 10-ны дотор цахим болон цаасан хэлбэрээр ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА- нд ирүүлнэ.

Гурав. Жилийн тайлан

3.1 Сарын мэдээг өссөн дүнгээр гаргаж жилийн тайланд тусгана.

3.2 Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн БЗДХ-ын кабинетийн эмч, БЗДХ-ын чиглэлээр ажиллаж буй хувийн хэвшлийн эмнэлгүүд нь үйл ажиллаагааны жилийн тайланг "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-304 тайлан" маягтын дагуу гарган дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-нд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.3 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-ны мэдээллийн мэргэжилтэн-статистикч их эмч үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авч нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 20-ны дотор ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-д цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.4 ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-ны статистикч эмч нь аймаг, нийслэлийн ЭМГ-аас ирүүлсэн "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-304 тайлан"-г хүлээн авч нэгтгэн үндэсний түвшинд цахим болон цаасан хэлбэрээр дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээлэх урсгал



12

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
11 дугаар сарын 27-ны өдрийн 450 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

СҮРЬЕЭ ӨВЧНИЙГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Сурьеэ өвчнийг бүртгэх

1.1 Аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, хувийн хэвшлийн эмнэлгүүд нь онош батлагдсан шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлыг "Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас" АМ-4 маягтаар бүртгэн аймаг, нийслэлийн ЭМГ-т мэдээлнэ.

1.2 Сүрьеэ өвчний улмаас нас барсан тохиолдлыг "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ" АМ-7 маягтаар бүртгэн мэдээлэх бөгөөд сарын шуурхай мэдээлэлд зөвхөн шинээр илэрсэн сүрьеэ өвчний улмаас нас барсан тохиолдлыг мэдээлнэ.

1.3 Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч нь "Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас"-аар (АМ-4 маягт), "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ"-ээр (АМ-7 маягт) бүртгэгдсэн тохиолдлыг ЭМЯ-наас хүлээн зөвшөөрсөн программ хангамжийг ашиглан цахим мэдээний санг үүсгэнэ.

1.4 Эмэнд дасалтай сүрьеэгийн сэжигтэй тохиолдол бүрийг ХӨСҮТ-ийн лавлах лабораториор баталгаажуулж олон эмэнд дасалтай сүрьеэтэй /ОЭДС/-тэй өвчтөний эмчилгээ хяналтын карт" ОЭДС-1 маягтаар бүртгэнэ.

Хоёр. Сарын мэдээ

2.1 Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч нь сар бүр тухайн сард шинээр илэрсэн сүрьеэгийн өвчлөл, нас баралтын тохиолдлыг аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-д мэдээлэх бөгөөд тус алба нь дараа сарын 4-ний дотор цахим хэлбэрээр үндэсний түвшинд мэдээлнэ.

2.2 Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч нь "Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас" АМ-4 маягтаар үүссэн цахим мэдээний санг бүртгэлийн маягтын хамт дараа сарын 10-ны дотор ХӨСҮТ-ийн СТСА-д сар бүр ирүүлж байна.

Гурав. Жилийн тайлан

3.1 Сарын мэдээг өссөн дүнгээр гаргаж жилийн тайланд тусгана.

3.2 Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн үйл ажиллагааны жилийн тайланг "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-302 тайлан" маягтын дагуу сүрьеэгийн зохицуулагч эмч гарган дараа оны 1 сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн ЭМГ-ын Сүрьеэгийн тандалт судалгааны алба /СМА/-д цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.3 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-ны мэдээллийн мэргэжилтэн-статистикч их эмч үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авч нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 20-ны дотор ХӨСҮТ-ийн СТСА -д цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.4 ХӨСҮТ-ийн СТСА -ны статистикч эмч нь аймаг, нийслэлийн ЭМГ-аас ирүүлсэн "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-302 тайлан"-г хүлээн авч нэгтгэн үндэсний түвшинд цахим болон цаасан хэлбэрээр дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээлэх урсгал



Эрүүл мэндийн сайдын 2013 оны
11 дугаар сарын 27-ны өдрийн 450 дугаар
тушаалын тавдугаар хавсралт

ХОРТ ХАВДРЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Хорт хавдрыг бүртгэх

1.1 Сум дундын эмнэлэг, аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, төв, хувийн хэвшлийн эмнэлгүүд нь онош батлагдсан шинээр илэрсэн хорт хавдрын тохиолдлыг "Хорт хавдрыг мэдээлэх хуудас" АМ-5 маягтаар бүртгэн аймаг, нийслэлийн ЭМГ-т мэдээлнэ.

1.2 Хорт хавдар өвчний улмаас нас барсан тохиолдлыг "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ" АМ-7 маягтаар бүртгэн мэдээлэх бөгөөд сарын шуурхай мэдээлэлд нийт (шинэ, хуучин) хорт хавдар өвчний улмаас нас барсан тохиолдлыг мэдээлнэ.

1.3 Аймаг, дүүргийн хавдрын кабинетийн эмч нь "Хорт хавдрыг мэдээлэх хуудас"-аар (АМ-5 маягт), "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ"-ээр (АМ-7 маягт) бүртгэгдсэн тохиолдлыг ЭМЯ-аас хүлээн зөвшөөрсөн программ хангамжийг ашиглан цахим мэдээний санг үүсгэнэ.

Хоёр. Сарын мэдээ

2.1 Аймаг, дүүргийн хавдрын кабинетийн эмч нь сар бүр тухайн сард шинээр илэрсэн хорт хавдрын өвчлөл, хорт хавдрын нийт нас баралтын тохиолдлыг аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-д мэдээлэх бөгөөд тус алба нь дараа сарын 4-ний дотор цахим хэлбэрээр үндэсний түвшинд мэдээлнэ.

2.2 Клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, төвүүд, ЭМЯ-аас тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эмнэлгүүд нь сар бүр тухайн сард шинээр илэрсэн хорт хавдрын өвчлөл, хорт хавдрын нийт нас баралтын тохиолдлыг дараа сарын 2-ны дотор цахим хэлбэрээр үндэсний түвшинд мэдээлнэ.

2.3 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн нэгдэл, клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, төвүүд, хувийн хэвшлийн эмнэлгүүд нь "Хорт хавдрыг мэдээлэх хуудас" АМ-5 маягтаар үүссэн цахим мэдээний санг бүртгэлийн маягтын хамт дараа сарын 10-ны дотор Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ)-ийн СМА-нд сар бүр ирүүлж байна.

Гурав. Жилийн тайлан

3.1 Сарын мэдээг өссөн дүнгээр гаргаж жилийн тайланд тусгана.

3.2 Аймаг, дүүргийн хавдрын үйл ажиллагааны жилийн тайланг "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-303 тайлан" маягтын дагуу хавдрын кабинетийн эмч гарган дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-д цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.3 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын СМА-ны мэдээллийн мэргэжилтэн-статистикч их эмч үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авч нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 20-ны дотор ХСҮТ-ийн СМА-нд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.4 ХСҮТ-ийн СМА нь аймаг, нийслэлийн ЭМГ-аас ирүүлсэн “Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-303 тайлан”-г хүлээн авч нэгтгэн үндэсний түвшинд цахим болон цаасан хэлбэрээр дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээлэх урсгал



Эрүүл мэндийн сайдын 2013 оны
11 дугаар сарын 27-ны өдрийн 450 дугаар
тушаалын зургаадугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БҮРТГЭЛИЙН БОЛОН ТАЙЛАНГИЙН МАЯГТЫН ЖАГСААЛТ, ХАДГАЛАХ ХУГАЦАА

Дугаар	Маягтын нэр	Маягтын дугаар	Хөтлөх хүний албан тушаал	Хадгалах хугацаа /жилээр/ цаасан хэлбэр	Хадгалах хугацаа /жилээр/ цахим хэлбэр
А. ӨРХ, СУМЫН ЭМНЭЛЭГТ ХӨТЛӨГДӨХ АНХАН ШАТНЫ МАЯГТ					
1	Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр	ӨЭ -1	Их эмч	Байнга	/-/
2	Өрхийн хүн амын эрүүл мэндийн бүртгэл	ӨЭ-2	Өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	Байнга	Байнга
3	Хүүхдийн эрүүл өсөлт, хөгжлийн хяналтын маягт	ӨЭ-3А	Өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	20	/-/
4	Хүүхдийн өсөлт ба хөгжлийн бүртгэлийн маягт	ӨЭ-3Б	Өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	20	/-/
5	Нэг долоо хоногоос 2 сар хүртэлх нярай хүүхдийн үзлэгийн маягт	ӨЭ-4А	Өрх болон сумын эмч	5	/-/
6	Хоёр сараас 5 хүртэлх насны өвчтэй хүүхдийн үзлэгийн маягт	ӨЭ-4Б	Өрх болон сумын эмч	15	/-/
7	Дархлаажуулалтад хамрагдсан 0-15 настай хүүхдийн нэгдсэн бүртгэл	ӨЭ-5	Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	5	/-/
8	0-15 настай хүүхдийг дархлаажуулах төлөвлөгөө, хамралтын сарын бүртгэл	ӨЭ-6	Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	5	5
9	Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын карт	ӨЭ-7	Вакцины сувилагч	15	15
10	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүртгэл	ӨЭ-8	Өрхийн их эмч, сувилагч	5	5
11	Хөгжлийн бэрхшээлтэй хүний ахиц дэвшлийг үнэлэх маягт	ӨЭ-9	Өрхийн их эмч, сувилагч	5	5

12	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст үзүүлсэн тусламжийн бүртгэл	ӨЭ-10	Өрхийн их эмч, сувилагч	5	5
13	Настны эрүүл мэндийн бүртгэл	АМ-28	Өрхийн их эмч, сувилагч	5	5
14	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгийн маягт	ХБӨЭИМ-1	Өрхийн их эмч, сувилагч	5	5
15	Чихрийн шижин хэв шинж 2 өвчний эрт илрүүлгийн үзлэгийн маягт	ХБӨЭИМ-2	Өрхийн их эмч, сувилагч	5	5
16	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгийн маягт	СМУ-2	Өрхийн их эмч, сувилагч	5	5
17	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгийн маягт	СМХ -2	Өрхийн их эмч, сувилагч	5	5
18	Эмчийн үзлэгийн бүртгэл	АМ-1А	Их эмч	5	5
19	Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас	АМ-2	Их эмч	5	5
20	БЗДХ-ыг мэдээлэх хуудас	АМ-3	Их эмч	5	5
21	Эмнэлгийн магадлагаа	АМ-8	Их эмч	/-/	/-/
22	Энгийн эмийн жор	АМ-9А	Их эмч	1	/-/
23	Мансууруулах эмийн жор	АМ-9Б	Их эмч	1	/-/
24	Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас	АМ-13А	Их эмч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
25	Эмнэлгээс өвчтөн илгээх хуудас	АМ-13Б	Их эмч	1	/-/
26	Хяналтын карт / диспансерийн /	АМ-11	Их эмч	Байнга	Байнга
27	Жирэмсэн эмэгтэйчүүдийн бүртгэл	АМ-14	Хяналтын эмч, эх баригч бага эмч	5	5
28	Жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтын хөтөч	АМ-15	Хяналтын эмч, эх баригч бага эмч	5	/-/
29	Солилцох хуудас	АМ-16	Хяналтын эмч, эх баригч бага эмч	Төрөлтийн түүхийн	/-/

				хамт	
30	Шинжилгээнд явуулах бичиг	АМ-21/А-Г/	Их эмч, сувилагч	/-/	/-/
31	Амбулаториор эмчлүүлэгсдийн карт	АМ-20	Их эмч, сувилагч	/-/	/-/
32	Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагсдын бүртгэл /амбулаторит/	АМ-27А	Их эмч, сувилагч	10	10

Б. АМБУЛАТОРИ ПОЛИКЛИНИКТ ХӨТЛӨГДӨХ АНХАН ШАТНЫ МАЯГТ

1	Эмчийн үзлэгийн бүртгэл	АМ-1Б	Их эмч	5	5
2	БЗДХ-ын кабинетын эмчийн үзлэгийн бүртгэл	АМ-1В	Их эмч, сувилагч	5	5
3	Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас	АМ-2	Их эмч	5	5
4	БЗДХ-ыг мэдээлэх хуудас	АМ-3	Их эмч	5	5
5	Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас	АМ-4	Их эмч	5	5
6	Хорт хавдрыг мэдээлэх хуудас	АМ-5	Их эмч	5	5
8	Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ	АМ-7	Их эмч, статистикч их эмч	20	20
9	Эмнэлгийн магадлагаа	АМ-8	Их эмч	/-/	/-/
10	Энгийн эмийн жор	АМ-9А	Их эмч	1	/-/
11	Мансууруулах эмийн жор	АМ-9Б	Их эмч	1	/-/
12	Эрүүл мэндийн хуудас	АМ-10	Их эмч	1	/-/
13	Хяналтын карт / диспансерийн /	АМ-11	Их эмч	Байнга	Байнга
14	Эмнэлэг хяналтын комиссоор орогчдын бүртгэл	АМ-12А	Эмч нарын комиссын нарийн бичгийн дарга	20	20
15	Комиссын шийдвэр	АМ-12Б	Эмч нарын комиссын нарийн бичгийн дарга	5	/-/
16	Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас	АМ-13А	Их эмч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
17	Эмнэлгээс өвчтөн илгээх хуудас	АМ-13Б	Их эмч	-	-
18	Жирэмсэн эмэгтэйчүүдийн бүртгэл	АМ-14	Хяналтын эмч, эх баригч бага эмч	5	5

19	Жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтын хөтөч	АМ-15	Хяналтын эмч, эх баригч бага эмч	5	/-/
20	Солилцох хуудас	АМ-16	Хяналтын эмч, эх баригч бага эмч	Төрөлтийн түүхийн хамт	/-/
21	Эхийн эндэгдлийг мэдээлэх карт	АМ-17	Их эмч	5	/-/
22	Үр хөндөлтийн түүх	АМ-18	Их эмч	5	5
23	Үр хөндөлтийн бүртгэл	АМ-19	Их эмч, сувилагч	5	5
24	Амбулаториор эмчлүүлэгсдийн карт	АМ-20	Их эмч, эх баригч бага эмч	2	2
25	Шинжилгээнд явуулах бичиг	АМ-21 (А-Г)	Их эмч, сувилагч	/-/	/-/
26	Лабораторийн шинжилгээний хуудсууд	АМ-22 (А-Й)	Лаборант	/-/	/-/
27	Лабораторийн шинжилгээний бүртгэл	АМ-23	Их эмч, лаборант	5	10
28	Үйл оношийн кабинетийн шинжилгээний бүртгэл	АМ-24	Их эмч, сувилагч	5	10
29	Сэргээн засах эмчилгээний карт	АМ-25А	Их эмч, сувилагч	5	/-/
30	Сэргээн засах эмчилгээний бүртгэл	АМ-25Б	Их эмч, сувилагч	5	5
31	Сувиллын эмчилгээний карт	АМ-26А	Их эмч, сувилагч	5	5
32	Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагсдын бүртгэл /амбулаторит/	АМ-27А	Их эмч, сувилагч	2	2
33	Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагсдын бүртгэл /стационарт/	АМ-27Б	Их эмч, сувилагч	2	2
34	Насны эрүүл мэндийн бүртгэл	АМ-28	Их эмч, сувилагч	10	10

В. СТАЦИОНАРТ ХӨТЛӨГДӨХ АНХАН ШАТНЫ МАЯГТ

1	Өвчний түүх	СТ-1А	Эмчлэгч эмч	50	50
	Дотрын эмчийн үзлэгийн хуудас		Эмчлэгч эмч	50	50
	Мэдрэлийн эмчийн үзлэгийн хуудас		Эмчлэгч эмч	50	50
	Нүдний эмчийн үзлэгийн хуудас		Эмчлэгч эмч	50	50
	Чих хамар хоолойн эмчийн үзлэгийн хуудас		Эмчлэгч эмч	50	50
	Арьс, харшлийн эмчийн үзлэгийн хуудас		Эмчлэгч эмч	50	50
	Дотоод шүүрлийн эмчийн үзлэгийн хуудас		Эмчлэгч эмч	50	50
	Гэмтлийн эмчийн үзлэгийн хуудас		Эмчлэгч эмч	50	50
	Уламжлалтын эмчийн үзлэгийн хуудас		Эмчлэгч эмч	50	50
	Эмэгтэйчүүдийн эмчийн үзлэгийн хуудас		Эмчлэгч эмч	50	50
	Цусны эмчийн үзлэгийн хуудас		Эмчлэгч эмч	50	50
	Сэтгэцийн эмчийн үзлэгийн хуудас		Эмчлэгч эмч	50	50
2	Өвчний түүх /хүүхдийн/	СТ-1Б	Эмчлэгч эмч	50	50
3	Эмчлүүлэгчийн хэрэглэсэн эмийн хуудас	СТ-1А,Б Хавсралт 1	Сувилагч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
4	Амин үзүүлэлтийн хуудас	СТ-1А,Б Хавсралт 2	Сувилагч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
5	Эрчимт эмчилгээний хяналтын хуудас	СТ-1А,Б Хавсралт 4	Их эмч, сувилагч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
6	Мэдээгүйжүүлэгч эмчийн үзлэг, мэдээ алдуулалтын явц, сэрээх үеийн хяналтын хуудас	СТ-1Б Хавсралт 5А	Их эмч, сувилагч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
7	Сэрээх үеийн хяналтын хуудас / хүүхэд /	СТ-1Б Хавсралт 5Б	Их эмч, сувилагч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт

8	Мэс заслын тэмдэглэл	СТ-1А,Б Хавсралт 6	Их эмч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
9	Мэс заслын хяналтын хуудас	СТ-1А,Б Хавсралт 7А	Их эмч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
10	Мэс засал хийлгэх зөвшөөрлийн хуудас	СТ-1А,Б Хавсралт 7Б		Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
11	Амь нас эрүүл мэнд эрсдэлтэй тусламж үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийн хуудас	СТ-1А,Б Хавсралт 7В	Их эмч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
12	Өөрийн хүсэлтээр эмнэлгээс гарах тухай зөвшөөрлийн хуудас	СТ-1А,Б Хавсралт 8		Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
13	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс татгалзсан тухай хуудас	СТ-1А,Б Хавсралт 9		Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
15	Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас	СМ-1 Хавсралт 11	Их эмч, сувилагч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
16	Сувилгааны тэмдэглэл	СМ-2 Хавсралт 12	Их эмч, сувилагч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
17	Өвдөлтийг хянах хуудас/сонгомолоор/	СМ-3 Хавсралт 13	Их эмч, сувилагч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
18	Шингэний балансийг хянах хуудас/сонгомолоор/	СМ-4 Хавсралт 14	Их эмч, сувилагч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
19	Гемодиализ хяналтын карт	СТ-2	Эмчлэгч эмч	5	/-/
20	Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ	АМ-7	Их эмч, статистикч их эмч	20	20
21	Төрөлтийн түүх	СТ-3	Их эмч	20	20
22	Кесар мэс заслын тэмдэглэл	СТ-3 Хавсралт 1	Их эмч	Төрөлтийн түүхийн	Төрөлтийн түүхийн

				хамт	хамт
23	Төрсөн эхийн мэдээлэх хуудас	СТ-4	Их эмч	5	/-/
24	Төрөлтийн бүртгэл	СТ-5	Эх баригч бага эмч	20	20
25	Эхийн амрах байраар үйлчлүүлэгчдийн бүртгэл	СТ-6	Амрах байрны сувилагч	20	20
26	Нярайн түүх	СТ-7	Нярайн их эмч, их эмч	15	15
27	Нярайн эрчимт эмчилгээний хяналтын хуудас	СТ-7 Хавсралт 1	Нярайн их эмч, нярайн сувилагч	Нярайн түүхийн хамт	Нярайн түүхийн хамт
28	Нярай хүүхдийн бүртгэл	СТ-8	Эх баригч бага эмч	5	5
29	Нярайн вакцин хийсэн тухай бүртгэл	СТ-9	Эх баригч бага эмч	5	5
30	Перинаталь эндэгдлийн карт	СТ-10	Их эмч	5	/-/
31	Эхийн эндэгдлийг мэдээлэх карт	АМ-17	Их эмч	5	/-/
32	Үр хөндөлтийн түүх	АМ-18	Их эмч	5	/-/
33	Үр хөндөлтийн бүртгэл	АМ-19	Их эмч, сувилагч	5	/-/
34	Эмчлүүлэгчийг эмнэлэг (сувилалд) хүлээн авсан бүртгэл	СТ-11А	Хүлээн авахын сувилагч	5	20
35	Яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэгсдийн бүртгэл	СТ-11Б	Хүлээн авахын сувилагч	5	20
36	Эмчлүүлэгсдийн өдөр тутмын тооцооны бүртгэл	СТ-12	Ахлах сувилагч, Сувилагч	2	/-/
37	Сэргээн засах эмчилгээний карт	АМ-25А	Их эмч, сувилагч	2	/-/
38	Сэргээн засах эмчилгээний бүртгэл	АМ-25Б	Их эмч, сувилагч	1	10
39	Эмч дуудах хуудас	СТ-13	Их эмч	1	/-/
40	Эмнэлгийн магадлагаа	АМ-8	Их эмч	/-/	/-/
41	Энгийн эмийн жор	АМ-9А	Их эмч	1	/-/
42	Мансууруулах эмийн жор	АМ-9Б	Их эмч	1	/-/
43	Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас	АМ-2	Их эмч	5	/-/
44	Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас	АМ-4	Их эмч	5	5
45	Хорт хавдрыг мэдээлэх хуудас	АМ-5	Их эмч	5	5
46	Цус цусан бүтээгдэхүүнийг сэлбэсэн протокол	СТ-14	Эмчлэгч эмч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
47	Цус цусан бүтээгдэхүүн захиалах маягт	СТ-15	Эмчлэгч эмч, сувилагч	5	/-/
48	Цусны албанд шинжилгээний сорьц хүргүүлэх	СТ-16	Эмчлэгч эмч, сувилагч	5	/-/

	маягт				
49	Цус цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой урвал хүндрэлийг мэдээлэх маягт	СТ-17	Эмчлэгч эмч, сувилагч	5	/-/
50	Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх зөвшөөрөл авах маягт	СТ-18	Эмчлэгч эмч	5	/-/
51	Цус, цусан бүтээгдхүүн сэлбэлттэй холбоотой урвал хүндрэлийн бүртгэл	СТ-19	Сувилагч	5	5
52	Цус, цусан бүтээгдхүүн захиалсан ба хүлээн авсан бүртгэл	СТ-20	Сувилагч	5	5
53	Насанд хүрэгчдийн түргэн тусламжийн дуудлагын хуудас	СТ-21А	Их эмч, сувилагч	5	6
54	Хүүхдийн түргэн тусламжийн дуудлагын хуудас	СТ-21Б	Их эмч, сувилагч	5	6
55	Халдвартай өвчний тусгаарлалт,халдваргүйтгэлийн дуудлагын хуудас	СТ-21В	Их эмч, сувилагч	5	6
56	Түргэн тусламжийн эмчийн ажлын тооцооны хуудас /насанд хүрэгчид/	СТ-22А	Их эмч	3	3
57	Хүүхдийн түргэн тусламжийн эмчийн ажлын тооцооны хуудас	СТ-22Б			
58	Алсын дуудлагын хуудас	СТ-23	Их эмч, сувилагч	3	3
59	Эмийн захиалгын түүвэр	СТ-24	Сувилагч	3	/-/
60	Тусгай хог хаягдлын устгалын бүртгэл	СТ-25	Сувилагч	1	/-/
61	Тусгай хог хаягдлын тандалт	СТ-26	Сувилагч	1	/-/
62	Ариутгалын бүртгэл	СТ-27	Сувилагч	1	/-/
63	Ариутгалд багаж материал хүлээн авч олгосон бүртгэл	СТ-28	Сувилагч	1	/-/

Г. ТӨРӨЛЖСӨН НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮДЭД ХӨТЛӨГДӨХ АНХАН ШАТНЫ МАЯГТ

1	Сүрьеэтэй өвчтөний бүртгэл	СҮ-1	Сувилагч	5	10
2	Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ хяналтын карт	СҮ-2	Их эмч	5	10
3	Цэрний шинжилгээний хуудас	СҮ-3	Лаборант	5	/-/
4	Өсгөвөрлөх шинжилгээний хуудас	СҮ-4	Лаборант	5	/-/
5	Сүрьеэтэй өвчтнийг шилжүүлэх хуудас	СҮ-5	Их эмч	5	/-/
6	Сүрьеэгийн диспансерийн лабораторийн шинжилгээний бүртгэл	СҮ-6	Лаборант	5	10
7	Сүрьеэ өвчний голомтын тархвар судалгааны хуудас	СҮ-7	Халдвар судлаач их эмч	5	/-/
8	ХДХВ-ийн халдвар, ДОХ-ын өвчлөлийг мэдээлэх хуудас	ХДХВ-1	Их эмч	5	10
9	ХДХВ-ийн халдварын тохиолдлын тандалтын хуудас	ХДХВ-2	Тархвар зүйч эмч Халдвар судлаач их эмч	5	/-/
10	ХДХВ/ДОХ-той өвчтөний нэгдсэн бүртгэл	ХДХВ-3	Их эмч, сувилагч	10	20
11	Эмнэлгийн хяналтанд бүртгэх маягт	ХДХВ-4	Хяналтын их эмч	10	/-/
12	Эмнэлгийн хяналтанд орсон ХДХВ/ДОХ-той өвчтөний нэгдсэн бүртгэл	ХДХВ-5	Хяналтын их эмч, сувилагч	10	10
13	Өвчтөний хяналтын бүртгэл	ХДХВ-6	Хяналтын их эмч, сувилагч	10	20
14	Эмнэлгийн давтан үзлэгийн маягт	ХДХВ-7	Хяналтын их эмч	10	/-/
15	Ретровирусийн эсрэг эмийн эмчилгээнд орсон ХДХВ / ДОХ-той өвчтөний нэгдсэн бүртгэл	ХДХВ-8	Хяналтын их эмч, сувилагч	10	20
16	РВЭ эмчилгээтэй үйлчлүүлэгчийн шилжүүлгийн хуудас	ХДХВ-9	Хяналтын их эмч	5	/-/
17	ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний лабораторийн бүртгэл	ХДХВ-10	Лабораторийн эмч, лаборант	5	10
18	Ийлдэс судлал болон ХДХВ илрүүлэх шинжилгээний бүртгэл	ХДХВ-11	Лабораторийн эмч, лаборант	5	10
19	Нян судлалын шинжилгээний бүртгэл	ХДХВ-12	Лабораторийн эмч, лаборант	5	10
20	ОЭДС-тэй өвчтөний эмчилгээ хяналтын карт	ОЭДС-1	Хяналтын их эмч	5	/-/

21	Өвчтөн шилжүүлэх маягт	ОЭДС- 2	Хяналтын их эмч	5	/-/
22	Эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээний бүртгэл	ОЭДС-3	Хяналтын их эмч	10	10
23	Эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээнд явуулах бичиг	ОЭДС-4	Хяналтын их эмч	5	/-/
24	Өсгөвөрийн шинжилгээний бүртгэл	ОЭДС-5	Хяналтын их эмч	10	10
25	ОЭДС-тэй өвчтөний эмч нарын зөвлөгөөний шийдвэр	ОЭДС-6	Хяналтын их эмч	5	/-/
26	Олон эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөний хавьталын судалгаа, хяналт	ОЭДС-7	Хяналтын их эмч	5	/-/
27	Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн бүртгэл	СЭ-1	Их эмч, сувилагч	10	20
28	Шүүх сэтгэц гэм судлалын магадлагаа	СЭ-2	Их эмч	10	/-/
29	Шүүх сэтгэц гэм судлалын магадлагааны бүртгэл	СЭ-3	Их эмч	10	20
30	Шүүх эмнэлгийн шинжээч эмчийн үзлэгийн бүртгэл	ШЭ-1	Шинжээч эмч	10	20
31	Шүүх эмнэлгийн задлан шинжилгээний бүртгэл	ШЭ-2	Шинжээч эмч	10	20
32	Шүүх эмнэлгийн эд эсийн шинжилгээний бүртгэл	ШЭ-3	Шинжээч эмч	25	25
33	Шүүх эмнэлгийн химийн шинжилгээний бүртгэл	ШЭ-4	Шинжээч эмч	25	25
34	Шүүх эмнэлгийн биологийн шинжилгээний бүртгэл	ШЭ-5	Шинжээч эмч	25	25
35	Шүүх эмнэлгийн хэргийн материалын бүртгэл	ШЭ-6	Шинжээч эмч	70	70
36	Шүүх эмнэлгийн шүүх химийн лабораторийншинжилгээнд ирүүлсэн материалыг дагалдах бичиг	ШЭ-7	Шинжээч эмч	25	/-/
37	Шүүх эмнэлгийн үзлэг хийсэн дүгнэлт	ШЭ-8	Шинжээч эмч	25	25
38	Шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийсэн дүгнэлт	ШЭ-9	Шинжээч эмч	25	25
39	Донорын эмчийн үзлэгийн бүртгэл	ЦТ-1	Их эмч	10	10
40	Цусны донорын эрүүл мэндийн карт	ЦТ-2	Их эмч	10	/-/
41	Эмнэлэгт олгосон цус цусан бүтээгдэхүүний бүртгэл	ЦТ-3	Их эмч, бага эмч	10	10
42	Захиалгат цус цусан бүтээгдэхүүн олгосон бүртгэл	ЦТ-4	Их эмч, бага эмч	10	10

43	Хаягдал цус цусан бүтээгдэхүүн шинжилгээний сорьцын устгалын бүртгэл	ЦТ-5	Цусны станцын сувилагч, ариутгагч	10	10
44	Цус сэлбэлттэй холбоотой урвал хүндрэлийн шалтгааныг судлах маягт	ЦТ-6	Их эмч,Тархвар зүйч эмч	5	/-/
45	Эмгэг судлалын шинжилгээний протокол	ЭС-1	Эмгэг судлаач их эмч	70	70
46	Биопси, мэс заслын сорьцын шинжилгээний бүртгэл	ЭС-2	Эмгэг судлаач их эмч	10	20
47	Биопси, мэс заслын сорьцын шинжилгээний илгээлт	ЭС-3	Эмгэг судлаач их эмч	10	/-/
48	Цогцсыг хүлээн авсан ба олгосон бүртгэл	ЭС-4	Эмгэг судлаач их эмч	50	50
49	Эмгэг судлалын задлан шинжилгээний бүртгэл	ЭС-5	Эмгэг судлаач их эмч	10	10

Д. ТАЙЛАНГИЙН МАЯГТУУД

1	Өрхийн эрүүл мэндийн төвийн тайлан	ЭМТ-101	Статистикч бага эмч	20	байнга
2	Сумын эрүүл мэндийн төвийн тайлан	ЭМТ-102	Статистикч бага эмч	20	байнга
3	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн тайлан	ЭМТ-103	Статистикч бага эмч	20	байнга
4	Аймаг, нийслэлийн тайлан	ЭМТ-201	Статистикч их эмч	20	байнга
5	Хувийн эмнэлгийн тайлан	ЭМТ-202	Их эмч	20	байнга
6	Сувиллын тайлан	ЭМТ-203	Их эмч	20	
7	Халдварт өвчин судлалын төв, кабинетийн үйл ажиллаагааны тайлан	ЭМТ-301	Кабинетийн их эмч	20	байнга
8	Сүрьеэгийн төв, кабинетийн үйл ажиллагааны тайлан	ЭМТ-302	Кабинетийн их эмч	20	байнга
9	Хавдар судлалын төв, кабинетийн үйл ажиллаагааны тайлан	ЭМТ-303	Кабинетийн их эмч	20	байнга
10	БЗДХ/ДОХ-ийн төв, кабинетийн үйл ажиллаагааны тайлан	ЭМТ-304	Кабинетийн их эмч	20	байнга
11	Сэтгэц, эмгэг мансуурал судлалын төв кабинетийн үйл ажиллагааны тайлан	ЭМТ-305	Кабинетийн их эмч	20	байнга
12	Шүүх эмнэлгийн үйл ажиллагааны тайлан	ЭМТ-306	Кабинетийн их эмч	20	байнга
13	Эмгэг судлалын үйл ажиллагааны тайлан	ЭМТ-307	Кабинетийн их эмч	20	байнга
14	Цусны төвийн үйл ажиллагааны тайлан	ЭМТ-308	Их эмч	20	байнга
15	Нүүр амны төв, кабинетийн үйл ажиллагааны тайлан	ЭМТ-309	Кабинетийн их эмч	20	байнга
16	Сургалт сурталчилгааны үйл ажиллагааны тайлан	ЭМТ-310	Сургалт сурталчилгаа хариуцсан арга зүйч	20	байнга
17	Геронтологийн төв, кабинетийн үйл ажиллагааны тайлан	ЭМТ-311	Кабинетийн их эмч	20	байнга
18	Эрүүл мэндийн байгууллагын хүн хүчний тайлан	ЭМТ-401	Хүний нөөцийн менежер, статистикч их эмч	20	байнга
19	Хүн амын өвчлөл эндэгдлийн сарын мэдээ	ЭМТ-501	Статистикч их эмч	20	байнга

20	Хүн амын амбулаторын өвчлөлийн тайлан	ЭМТ-502	Статистикч их эмч	20	байнга
21	Хүн амын стационарын өвчлөлийн тайлан	ЭМТ-503	Статистикч их эмч	20	байнга
22	Хүн амын нас баралтын тайлан	ЭМТ-504	Статистикч их эмч	20	байнга

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ХӨТЛӨГДӨХ АНХАН ШАТНЫ БҮРТГЭЛИЙН МАЯГТЫН ЭМХЭТГЭЛ

ЭМСайдын 2013 оны 11 сарын 450 тоот тушаалаар батлав
Эрүүл мэндийн бүртгэлийн маягт ӨЭ-1

ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭВТЭР

Эхийн мэдээлэл:			
Ургийн овог:	**Хот, аймаг, дүүрэг**	**Сум, хороо**	**Баг, хэсэг**
Эцэг / эхийн нэр:			
Нэр:	**Гэрийн хаяг, утас:**		
Яс үндэс:	**Ажлын газар, албан тушаал, утас:**		
Мэргэжил: / **Боловсрол:**	**Гэр бүлийн байдал:**	**Ам бүлийн тоо:**	
Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар:	**Регистрийн дугаар:**		
Биеийн өндөр (см)	**Ердийн жин (кг)**	**Гэрлэсэн нас**	

Хүүхдийн төрсөн тухай батламж	Төрөх тасаг бүхий Эрүүл мэндийн байгууллагын нэр, тамга		
Ургийн овог:	**Хүйс:** ЭР / ЭМ *Хүүхдийн хүйсийг заавал дугуйлан тэмдэглэ!*		
Эцэг / эхийн нэр:	**Хот, аймаг, дүүрэг**	**Сум, хороо**	**Баг, хэсэг**
Хүүхдийн нэр:	**Гэрийн хаяг:**		
Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар:	**Регистрийн дугаар:**		

Төрсөн он	**сар**	**өдөр**	**цаг**	**Дээрх хүүхдийн төрснийг 20... оны .... сарын .... өдөр албан ёсоор бүртгэсэн болно.**

Төрснөөс хойш 14 хоногийн дотор хүүхдээ бүртгүүлж Төрсний гэрчилгээг авах ёстой!

Эх хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийн байдлыг дэмжих, үнэлэх зориулалттай бүртгэл

Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр бол жирэмсэн эмэгтэй та болон танай хүүхдийн эрүүл мэнд, өсөлт ба хөгжлийг бүртгэх үндсэн баримт нь болно.

Эцэг эх, асран хамгаалагч та:
Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн цэнхэр хүрээтэй хуудсуудад тэмдэглэл хөтөлж бөглөнө.
Эрүүл мэндийн ажилтан та:
Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн улаан хүрээтэй хуудсуудад тэмдэглэл хөтөлж бөглөнө.
Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт танай хүүхдийг насанд нь болон хэрэгцээ шаардлагад нь тохируулан хэрхэн асрах, яаж хооллох тухай зөвлөмжүүдийг багтаасан.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг та болон хүүхдийг тань асран хамгаалж буй хэн ч гэсэн хэрэглэх боломжтой. Иймд энэ бүртгэлийн товхимлыг нандигнан хадгалахаас гадна дараах тохиолдлуудад хүүхдийн биед заавал авч явна.

- Эрүүл мэндийн төв, амбулатори болон сум, өрхийн эмнэлгээр үйлчлүүлэх (эрүүл мэндийн үзлэг, хяналт, шинжилгээ, хүүхэд өвчилсөн үед эсвэл зүгээр үйлчилгээ авах гэж очихдоо)

- Эмч болон бусад эрүүл мэндийн ажилтнуудтай уулзан зөвлөгөө авах үед
- Дархлаажуулалтад хамрагдах үед
- Шүдний эмчид үзүүлэх үед
- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх болон осол, гамшигт өртсөн тохиолдолд
- Эрүүл мэндтэй холбоотой бусад асуудлууд тохиосон үед үргэлж авч ирээрэй

Огноо	Ирсэн шалтгаан	Огноо	Ирсэн шалтгаан

ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Дараах өвчнөөр өвчилж байсан уу? ☑ гэж тэмдэглэнэ

☐ Цусны даралт ихсэх, ☐ Бөөрний архаг үрэвсэл, ☐ Чихрийн шижин,
☐ Халдварт шар өвчин ☐ Зүрхний өвчин, ☐ Бамбай булчирхайн өвчин,
☐ Бусад өвчин (нэрлэнэ үү) _____
_____

Дараах халдварт өвчнөөр өвчилж байсан уу? (дугуйлан зур)

Улаануud	Тийм _____ Үгүй	Вакцин хийлгэсэн / Үгүй
Улаанбурхан	Тийм _____ Үгүй	Вакцин хийлгэсэн / Үгүй
Салхин цэцэг	Тийм _____ Үгүй	Вакцин хийлгэсэн / Үгүй

Мэс засал хийлгүүлж байсан уу? Тийм / Үгүй

Тийм бол ямар: _____

Тамхи татдаг уу? Тийм (өдөрт _____ тамхи татдаг) / Үгүй

Архи хэрэглэдэг уу? Тийм Үгүй Хааяа

Нөхрийн эрүүл мэнд: Сайн/Муу (Өвчин юм уу зовиур: _____)

Нөхрийн цусны бүлэг: A B O

Энэ дэвтрийг эмчид үзүүлэхдээ авчирна уу. Эмнэлэг эмч өөрчлөгдсөн тохиолдолд энэ дэвтэр таны эрүүл мэндийн түүх болох тул хаяж гээгдүүлж болохгүй.

Хэдэн удаа жирэмсэлсэн _____
Хэдэн удаа төрсөн _____
Одоо хэдэн хүүхэдтэй _____
Үүний өмнөх жирэмслэлт хэдийд яаж төгссөн? _____
Дутуу төрж байсан эсэх (жирэмсний 22 – 36 долоо хоног хүртэл)_____хэдэн удаа?
Зулбаж байсан эсэх (жирэмсний 22 долоо хоногоос өмнө) _____ хэдэн удаа?

Эхийн тухай мэдээлэл:

<table>
<tr><td rowspan="6">Жирэмсэн үеийн хөдөлмөрийн нөхцөл</td><td>Одоо ажил хийдэг үү?</td><td colspan="3">Одоогоор ажилгүй/ орон тооны ажилтан/ орон тооны бус ажилтан/ хувиараа хөдөлмөр эрхэлдэг/ гэрээр ажилладаг бусад (_____)</td></tr>
<tr><td>Ямар ажил эрхэлдэг вэ?</td><td colspan="3"></td></tr>
<tr><td>Өдөрт хэдэн цаг ажилладаг вэ?</td><td colspan="3">( ) цаг, завсарлага ( ) минут</td></tr>
<tr><td>Ажилдаа яаж очдог вэ?</td><td colspan="3">Нийтийн тээвэр, такси, явган, хувийн тэргээ өөрөө жолоодож</td></tr>
<tr><td rowspan="2">Ажилдаа хэдэн минут, цаг явж хүрдэг вэ?</td><td rowspan="2">Нэг талдаа ( ) минут</td><td rowspan="2">Хэр шахцалддаг вэ?</td><td>Маш их шахцалддаг</td></tr>
<tr><td>Хэвийн</td></tr>
<tr><td colspan="2" rowspan="3">Жирэмсэн байх үеийн ажлын нөхцөл байдал</td><td colspan="3">Хортой / Хүнд / Хэвийн / Бусад_____</td></tr>
<tr><td colspan="3">Ажлаа сольсон: (_____ жирэмсний долоо хоногт)</td></tr>
<tr><td colspan="3">Бусад: _____</td></tr>
<tr><td colspan="2">Төрөхийн өмнөх жирэмсний амралт</td><td colspan="3">_____ жирэмсний долоо хоногтойгоос буюу _____ (сараас) _____ (өдрөөс) нийт _____ өдөр</td></tr>
<tr><td colspan="2">Төрсний дараах амралт</td><td colspan="3">_____(сараас)_____(өдрөөс) нийт _____ өдөр</td></tr>
<tr><td colspan="2">Амьдралын нөхцөл байдал</td><td colspan="3">Амины сууц /Орон сууцны байранд/ Гэрт / Бусад</td></tr>
<tr><td colspan="2" rowspan="2">Хэнтэй хамт амьдардаг вэ?</td><td colspan="3">Хүүхдүүд: (тоо:_____), Нөхөр, Хадам аав, Хадам ээж</td></tr>
<tr><td colspan="3">Өөрийн аав, өөрийн ээж, бусад (тоо:_____)</td></tr>
</table>

Жирэмслэлтийн талаарх мэдээлэл

37

Сүүлийн сарын тэмдэг ирсэн эхний өдөр		20_ оны ____сарын _____
Ургийн анхны хөдөлгөөнийг мэдэрсэн өдөр (нөхөж бич!)		20_ оны ____сарын _____
Амаржих товлол: (сүүлийн сарын тэмдэг ирсэн өдөр дээр 7-г нэмж сараас нь 3-г хасна)		20_ оны ____сарын _____
Жирэмслэлтээс хамгаалах ямар арга хэрэглэдэг байсан (бич)		
Цусны бүлэг (зүр)	A B O Ph + -	20_ оны ____сарын _____

Жирэмсний 10-12 долоо хоногтойд таны мэдэж байх зүйлс:

- Таны биед илрэх хэвийн өөрчлөлтүүд нь: ядарч сульдах; бөөлжис цутгах болон хөнгөн бөөлжих; толгой өвдөх; бие сулрах, мөн таны хөх хэмжээгээрээ томорч зөөлөрнө.
- Хэвлий дэх хүүхдийн зүрх цохилж , гар, хөл, нүүр болон бусад том эрхтнүүд хэлбэрээ олж эхэлнэ.
- Үтрээнээс ялгарах шингэн нэмэгдэж байвал хэвийн үзэгдэл гэж тооцоорой.
- Жирэмсний хугацаанд бие дэх бодисын солилцоо өөрчлөгддөг тул буйлны өвчинд өртөх эрсдэл илэрч болох юм.

Буйлны хүнд өвчин нь ураг хэт дутуу болон хэт бага жинтэй төрөхөд нөлөөлдөг байна.

- Жирэмсэн үедээ шүдний эмчид заавал хандаарай.

Дараах асуудлуудыг эмчтэйгээ зөвлөж ярилцаарай:

- Би бэлгийн харьцаанд орж болох уу?
- Миний шинжилгээний хариу хэвийн байна уу?
- Би хөхөө яаж өөрөө арчлах вэ?
- Энэ жирэмсэлтэд миний нас нөлөөтэй юү?
- Эмнэлэгт үзүүлэхддээ хүүхдийнхээ аавтай хамт ирж болох уу?
- Халуун ус, саун, рашаан шүршүүрт ороход хүүхдэд нөлөөлөх үү?

Таны тэмдэглэл болон мэдэхийг хүсэж буй зүйлүүд

Жирэмсний 12-16 долоо хоногтойд таны мэдэж байх зүйлс:

- Таны биед илрэх хэвийн өөрчлөлтүүд нь: Хааяа хамраас цус гарах, үтрээнээс өнгөгүй шингэн ялгадас гарах, ууц нуруугаар чилэх

Жирэмсний эхэн үед илэрч байсан дотор муухайрах огиулах, бөөлжих болон ядарч сульдах нь багасна

- Энэ үед хэвлий дэх хүүхдийн яснууд бүрэлдэн бэхжиж эхэлдэг
- **Дараах асуудлуудыг эмчтэйгээ зөвлөж ярилцаарай:**
- Ууц нуруугаар хөшиж өвдөхийг намдаахын тулд би ямар дасгалууд хийх вэ?
- Жирэмсэн эмэгтэйчүүдэд цус багадалт (төмрийн дутал) яагаад илэрдэг вэ?
- Би нэмэлт төмрийн бэлдмэл уух шаардлагатай юу?
- Жирэмсэн үед хамраас цус гарах шалтгаан нь юу вэ?
- Хүүхдийнхээ хүйсийг хэдийд мэдэж болох вэ?

Таны тэмдэглэл болон мэдэхийг хүсэж буй зүйлүүд

Жирэмсний 16-20 долоо хоногтойд таны мэдэж байх зүйлс:

- Таны биед илрэх хэвийн өөрчлөлтүүд нь: Хэхрэх болон гэдсэнд хий дүүрэх, амьсгаадах, хацар, хамар, дух сэвхтэх болон хөхний толгойн өнгө бараан болж өөрчлөгдөнө.
- Хэвлий дэх хүүхдийн эрхтнүүд хэлбэрээ олж өсч томорч байна.
- Сулхан түлхэх хөдөлгөөнийг мэдэрч эхэлнэ (Хуудас 5-д тэмдэглээрэй!).
- Жирэмсэн байх хугацаанд сэтгэлийн хөөрөл болон сэтгэл гутрал давхцаж байдаг.

Хэрэв та хэт их сэтгэлийн хөөрөл болон гутралтай байвал эмчдээ хандаарай.

Дараах асуудлуудыг эмчтэйгээ зөвлөж ярилцаарай:

- Хүүхдээ хэрхэн төрүүлэх, хөхүүлэх, хүүхдийн асаргааны талаар хаанаас мэдэж болох энэ талын сургалтанд би хэрхэн хамрагдаж болох вэ?
- Миний амьсгал яагаад давчдаад байна вэ, үүнийг би яаж зохицуулах вэ?
- Хүүхдээ хөхүүлэх нь угжаар хооллохоос яагаад давуу талтай вэ?

Таны тэмдэглэл болон мэдэхийг хүсэж буй зүйлүүд

Жирэмсний 20-24 долоо хоногтойд мэдэж байх зүйлс:

- Таны биед илрэх хэвийн өөрчлөлтүүд нь: хамраас цус гарах, үтрээнээс өнгөгүй шингэн гарах; ангир уураг ялгарч эхэлнэ: хөхнөөс шаргалдуу цэхэр өнгөтэй шингэн ялгарах ба энэ нь таны хүүхдийн анхны хоол болох ёстой юм.
- Хэвлий дэх хүүхдийн зүрхний цохилт чагнуурт сонсогдоно. Толгойн үс, сормуус нь ургаж эхэлж байгаа.
- Хүүхэд зулбах, дутуу төрж болзошгүй шинж тэмдгүүд: Умайн булчингийн агчиж чангарах, хэвлийн доод хэсгээр тогтмол базлахх, үтрээнээс ялгарах шингэний хэмжээ нэмэгдэж, тунгалаг усархаг эсвэл цусархаг өнгөтэй болно. Хэрэв эдгээр шинжүүд илэрвэл яаралтай эмнэлэгт хандах буюу эмч дуудаарай.
- Нурууны өвдөлтөөс сэргийлэхийн тулд намхан өсгийтэй гутал өмсөөрэй.

Дараах асуудлуудыг эмчтэйгээ зөвлөж ярилцаарай:

- Арьс сэвхтэх, нөсөөтөх, хэвлий болон нуруу өгзөөр судал, язралт үүсэхийн шалтгаан нь юу вэ? Цаашдаа арилах уу?

Хугацаанаас өмнө өвдвөл яах вэ? Ус эрт гарвал яах вэ? Резус хүчин зүйл гэж юу вэ?

Таны тэмдэглэл болон мэдэхийг хүсэж буй зүйлүүд

Жирэмсний 24-28 долоо хоногтойд таны мэдэж байх зүйлс:

• Таны биед илрэх хэвийн өөрчлөлтүүд нь: Ууц нуруугаар чилэх, өтгөн хатах, цагаан мах гарах, буйл хавагнах ба буйлнаас цус гарах, ангир уураг ялгарах, хэхрэх ба гэдсэнд хий дүүрэх, амьсгаадах, хөл, гар хөөнгөтөх , үтрээнээс шингэн ялгарах, хөлийн судас өргөсөх.

• Хүүхэд эхийнхээ хэвлийд эрхий хуруугаа хөхөх, хөдөлж тийчигнэх нь ихэсдэг. Шүднийх нь бүтэц бүрэлдэж эхэлнэ.

• Та шүдний эмчид үзүүлээгүй удсан бол очиж үзүүлээрэй.

Дараах асуудлуудыг эмчтэйгээ зөвлөж ярилцаарай:

• Өтгөн хаталт, шамбарамтай холбоотой зовиураа арилгахын тулд би яах вэ?

• Жирэмсний шижин гэж юу вэ? Жирэмсний шижинтэй эсэхээ би яаж мэдэх вэ?

Таны тэмдэглэл болон мэдэхийг хүсэж буй зүйлүүд

Жирэмсний 28-32 долоо хоногтойд мэдэж байх зүйлс:

• Таны биед илрэх хэвийн өөрчлөлтүүд нь: Дээр дурьдаж байсан бүх шинжүүд дээр нэмэгдэж хэвлийгээр бага зэрэг хатуурах, нуруугаар өвдөх, бие сулрах, зүрх дэлсэх, жирэмсний судал язралт үүсэх, ядрах зэрэг байдал илэрнэ.

• Хэвлий дэх хүүхэд чинь их түргэн өсч байгаа бөгөөд нүдээ нээж, гар болон хөлөө чөлөөтэй хөдөлгөж чадаж байгаа.

• Өдөрт 3 удаа их хэмжээгээр иддэг байсан бол одоо бага багаар олон удаа ид. Ингэх нь зарим эмэгтэйд хэхрэх, таагүй байх зэргийг бууруулж тусална.

• Удаан хугацаагаар ханиах, зүрх дэлсэж зүрхний цохилт түргэсэх, бэлэг эрхтэн загатнах, үтрээнээс идээт ялгадас гарвал яаралтай эмчид хандаарай

Дараах асуудлуудыг эмчтэйгээ зөвлөж ярилцаарай :

• Миний жирэмсэлтийн явцад (төмөр дутлын) цус багадалт хэрхэн яаж нөлөөлөх вэ?

• Миний гар, хөл хавагнаж байвал би яах ёстой вэ?

• Хүүхдийнхээ хөдөлж буйн шинж тэмдгийг би хэрхэн мэдэх вэ? Ургийн хөдөлгөөнийг тоолох гэж юу вэ?

• Би бэлгийн харьцаанд орж болох уу?

• Ажлаа хийсээр байж болох уу?

Таны тэмдэглэл болон мэдэхийг хүсэж буй зүйлүүд

Жирэмсний 32-34 долоо хоногтойд мэдэж байх зүйлс:

- Таны биед илрэх хэвийн өөрчлөлтүүд нь: хөлийн шөрмөс татах, амьсгал давчдах, нойронд муудах болон өмнө нь дурьдсан бүх шинжүүд.
- Хүүхдийн хөдөлж байгаа нь гаднаас мэдэгдэж, харагдана.
- Зулбах эсвэл дутуу төрөх эрсдлийн шинж тэмдэг байгаа эсэхийг шалгаарай (хуудас 8 -аас хар).

Дараах асуудлуудыг эмчтэйгээ зөвлөж ярилцаарай:

- Төрөлтийн талаар төлөвлөгөөгөө бичиж (ямар эмнэлэт амаржих, эмнэлэгтээ хэдийд ямар унаагаар очих, эхийн амрах байр гм) эмчтэйгээ ярилцаарай.
- Умайн булчингийн агчилтыг бууруулах, намдаахын тулд миний зүгээс юу хийх вэ?
- Хүүхдээ хөхүүлэхэд бэлтгэхийн тулд би юу мэдэж сурах ёстой вэ?
- Хэрэв миний цусны даралт их бол яах вэ? Цусны даралт ихтэй эсэхээ яаж мэдэх вэ? Хэрэв би цусны даралт ихтэй бол миний хүүхдэд яаж нөлөөлөх вэ?

Таны тэмдэглэл болон мэдэхийг хүсэж буй зүйлүүд

Жирэмсний 34-37 долоо хоногтойд мэдэж байх зүйлс:

- Таны хүүхдийн жин ойролцоогоор 2.5 кг байна.
- Эмчээсээ В бүлгийн стрептококкийн халдварын шинжилгээний дүнг асуу.
- Амаржих газарт ирэхэд шаардлагатай зүйлсээ бэлтгэ. Үүнд: саван шүдний оо сойз, солих хувцаснууд, гар нүүрийн алчуур, шаахай, хөхний даруулга, дотуур хувцас, ариун цэврийн хэрэгсэл, хүүхдийн өлгий, малгай, хувцас, живх, эрүүл мэндийн дэвтэр, ойр зуурын бэлэн мөнгө, орны хэрэгсэл гэх мэт

